Grant Thornton

**"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК**
**Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм**

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар 14230, Монгол улс
Т +976 70 110744
+976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street, Sukhbaatar District-1, Ulaanbaatar 14230, Mongolia
T +976 70 110744
+976 70 110799

# Санхүүгийн хураангуй тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

**"Мандал даатгал"** ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

***Дүгнэлт***

Бид "Мандал даатгал" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын батлсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

***Хураангуй санхүүгийн тайлан***

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан "Даатгалын компаниудад мөрдөгдөх Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Мандал даатгал" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.
Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

***Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт***

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зэрэг дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд доорх асуудал багтсан.

- Аудитын гол асуудал - Аудитын гол асуудал нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн их нөлөөтэй асуудал болох "Нөөц сангийн тооцоолол" байсан.

***Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага***

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

***Аудиторын үүрэг хариуцлага***

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

GRANT THORNTON AUDIT LLC
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1118276081 2577542

....................................

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**

Монгол улс, Улаанбаатар хот
2020 оны 2 дугаар сарын 28

# Санхүүгийн байдлын тайлан

| Мянган төгрөгөөр | Тодруулга | 2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| *Хөрөнгө* | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 904,137 | 3,082,303 |
| Даатгалын авлага | 5 | 6,253,418 | 4,816,979 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 6 | 618,472 | 303,965 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 7 | 867,694 | 1,233,157 |
| Хөрөнгө оруулалт | 8 | 27,638,364 | 19,837,291 |
| Даатгалын хөрөнгө | 9 | 3,857,214 | 3,888,840 |
| Үндсэн хөрөнгө | 10 | 537,192 | 351,967 |
| Биет бус хөрөнгө | 11 | 69,519 | 33,147 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 12 | - | 230,640 |
| | | **40,746,010** | **33,784,289** |
| *Өр төлбөр ба эзэмшигчийн өмч* | | | |
| *Өр төлбөр* | | | |
| Даатгалын өглөг | 13 | 1,850,517 | 1,065,374 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 14 | 738,085 | 645,614 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 15 | 12,834,046 | 13,115,353 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 16 | 4,594,113 | 3,383,397 |
| | | 20,016,761 | 18,209,738 |
| *Эздийн өмч* | 17 | | |
| Хувьцаат капитал | | 6,243,016 | 6,243,016 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 4,441,896 | 4,441,896 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | (71,097) | 20,490 |
| Хуримтлагдсан ашиг | | 10,115,434 | 4,860,149 |
| | | 20,729,249 | 15,574,551 |
| Нийт өмч ба өр төлбөр | | **40,746,010** | **33,784,289** |

Энэхүү санхүү байдлын тайланг 10-аас 28 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мөр | Мянган төгрөгөөр | Тодруулга | 2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|---|---|
| 1 | Даатгалын хураамжийн нийт орлого | 18 | 28,927,212 | 27,786,499 |
| 2 | Даатгалын хураамжийн буцаалт | 18 | (2,210,956) | (1,529,982) |
| 3 | Давхар даатгалын хураамжийн зардал | 18 | (10,842,392) | (9,807,090) |
| 4 | Даатгалын хураамжийн цэвэр орлого (1+2+3) | | 15,873,864 | 16,449,427 |
| 5 | Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | 18 | 281,307 | (3,749,075) |
| 6 | Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт | 18 | 267,079 | (768,662) |
| 7 | Орлогод тооцсон хураамж (4+5+6) | | 16,422,250 | 11,931,690 |
| 8 | Нийт нөхөн төлбөрийн зардал | 18 | (5,422,537) | (4,324,094) |
| 9 | Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр | 18 | 674,283 | 790,080 |
| 10 | Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр | 18 | 384,427 | 247,954 |
| 11 | Нөхөн төлбөрийн цэвэр зардал (8+9+10) | | (4,363,827) | (3,286,060) |
| 12 | Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт | 18 | (1,683,438) | (424,881) |
| 13 | Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | 18 | (415,132) | (166,407) |
| 14 | Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт | 18 | 472,722 | (47,858) |
| 15 | Зардалд тооцсон нөхөн төлбөр (11+12+13+14) | | (5,989,675) | (3,925,206) |
| 16 | Даатгалын гэрээний зардал | 19 | (1,177,917) | (1,315,776) |
| 17 | Давхар даатгалын шимтгэлийн орлого | 20 | 82,585 | 438,772 |
| 18 | Хөрөнгө оруулалтын орлого | 21 | 3,734,284 | 2,248,376 |
| 19 | Даатгалын үйл ажиллагааны ашиг (7+15+16+17+18) | | 13,071,527 | 9,377,856 |
| 20 | Хүү, эрхийн шимтгэлийн орлого | | 26,127 | 28,082 |
| 21 | Бусад орлого | | 51,451 | 74,650 |
| 22 | Ерөнхий ба удирдлагын зардал | 22 | (5,611,432) | (3,986,955) |
| 23 | Борлуулалт, маркетингийн зардал | 23 | (1,014,256) | (608,100) |
| 24 | Бусад зардал | 24 | (3,104) | (555,127) |
| 25 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | | 14,956 | 81,781 |
| 26 | Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз | | 366 | (38,566) |
| 27 | Бусад алдагдал (20+21+22+23+24+25+26) | | (6,535,892) | (5,004,235) |

| Мөр | Мянган төгрөгөөр | Тодруулга | 2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|---|---|
| 28 | Татвар төлөхийн өмнөх ашиг (19+27) | | 6,535,635 | 4,373,621 |
| 29 | Орлогын татварын зардал | 25 | (665,047) | (505,364) |
| 30 | Татварын дараах ашиг (28+29) | | 5,870,588 | 3,868,257 |
| | Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл | | (91,587) | 20,490 |
| | Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | | 5,779,001 | 3,888,747 |
| | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг | | 0.009* | 0.623 |

*2019 оны 4-р сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 6,243,016 ширхэг энгийн хувьцааг 100 хувааж 624,301,600 ширхэг хувьцаа болгох шийдвэр гарсантай холбоотойгоор тайлант оны нэгж хувьцаанд ногдох суурь ашгийн үзүүлэлт юм.

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг 10-аас 28 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

| Мянган төгрөгөөр | Хувьцаат капитал | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг /алдагдал | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **2018.01.01** | **6,243,016** | **(1,243,016)** | **-** | **-** | **1,000,892** | **6,000,892** |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | - | 3,868,257 | 3,868,257 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | 1,243,016 | 4,441,896 | - | - | 5,684,912 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | | 20,490 | - | 20,490 |
| **2018.12.31** | **6,243,016** | **-** | **4,441,896** | **20,490** | **4,869,149** | **15,574,551** |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | - | 5,870,588 | 5,870,588 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | (91,587) | - | (91,587) |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | (624,302) | (624,302) |
| **2019.12.31** | **6,243,016** | **-** | **4,441,896** | **(71,097)** | **10,115,434** | **20,729,249** |

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг 10-аас 28 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# Мөнгөн гүйлгээний тайлан

| Мянган төгрөгөөр | 2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2018 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| *Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Даатгалын хураамжийн орлого | 24,985,154 | 21,581,831 |
| Давхар даатгалын нөхөн төлбөр | 731,903 | 243,513 |
| Бусад мөнгөн орлого | 1,088,609 | 2,663,208 |
| Ажиллагчдад төлсөн | (2,494,071) | (2,094,710) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (621,390) | (465,100) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | - | (4,153) |
| Ашиглалтын зардалд төлсөн | (12,701) | - |
| Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж | (10,039,789) | (10,060,111) |
| Нөхөн төлбөрт төлсөн | (5,335,014) | (4,245,308) |
| Үүнээс: Сайн дурын даатгалын | (5,069,365) | (3,501,883) |
| Албан журмын даатгалын | (265,649) | (743,425) |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | (75,725) | (96,165) |
| Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр | (714,760) | (496,281) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (39,782) | (69,167) |
| Татварын байгууллагад төлсөн | (989,476) | (865,300) |
| Даатгалын төлбөрт төлсөн | (2,834) | (1,957) |
| Бусад мөнгөн зарлага | (3,747,725) | (3,036,745) |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн*** | **2,732,399** | **3,053,555** |
| *Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 587 | 31,365 |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 34,522,997 | 6,181,039 |
| Хүлээн авсан хүүний орлого | 3,367,923 | 2,012,377 |
| Хүлээн авсан ногдол ашиг | 30,391 | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (189,342) | (115,761) |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (48,541) | - |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | (42,033,190) | (15,862,327) |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн*** | **(4,349,175)** | **(7,753,307)** |
| *Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | 5,976,848 |
| Төлсөн ногдол ашиг | (561,390) | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(561,390)** | **5,976,848** |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (2,178,166) | 1,277,096 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,082,303 | 1,805,207 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **904,137** | **3,082,303** |

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг 10-аас 28 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.